

УДК 24

## АЛТАЙН ЗАХЧИНЫ ХУТАГТЫН ДАЦАН

**Ядамжав Г.**

магистр, «Тод номын гэрэл төв»

Улаанбаатар, Монгол Улс

E-mail: yadamjab@yahoo.com

### Товч хураангуй

Захчины сүм хийд нь Ойрад Зүүнгарын хаант улсын сүм хийдийн үргэлжлэл болох бөгөөд Ойрадын сүм хийд нь анх Байвгас баатар тэргүүлэн Ойрадын бүх ноёд нэг нэг хөвгүүнээ хоёр зуун эгэл ардын хөвүүний хамт лам болгохоор Төвд оронд Далай лам, Банчин богдын дэргэд хүргэж, дээдийн номонд сурган бурхан шашинтан болсноор эхэлсэн ба энэ анхлан суралцагч нарын дундаас алдарт хутагт Равжамба Зая бандида Намхайжамц, Ачит цорж, Дархан цорж, Даржаа гавж, Равжамба Содов тэргүүтэн олон номт мэргэд гарч Богд Зонховын өнө ёс шар малгайтны шашин, Далай лам, Банчин богдын зарлиг номын эш онолоор Ойрад нутагтаа «Ойрадын их хүрээ»-г байгуулж, шашин эхлүүлсэн билээ. Равжамба Зая бандида Ойрадын их хүрээг байгуулаад, олон зуун шавь нарыг боловсруулснаас Мэргэн хэлмэрч Агваанлоройжамц, Раднаабадраа, Үйзэн нансо, Гүнтэн гавж, Эрх цорж, Шарав гэлэн, Тарва гавж, Дайчин нансо тэргүүтэн гарсан. Равжамба Зая бандида «Ойрадын их хүрээ»-г байгуулаад, түүнээсээ салбарлан олон хийд сүмийг үүсгэн байгуулж, Халх, Өвөрлөгч, Халимагт шашин соёл дэлгэрүүлэх томоохон үйл ажилгааг хийж байсан ба Төвд, Манжид ч нөлөө үзүүлсэн шашин соёлийн томоохон зүтгэлтэн байсныг түүхэнд тэмдэглэсэн байдаг.

### Түлхүүрүг

Захчины сүм хийд, Равжамба Зая бандида, ойрад, шашин.

UDC 24

## ALTAI ZAHCHIN'S KHUTAGTYN DATSAN

---

**Yadamjav G.**

magistr, «Tod nomyn gerel töv»

Ulaanbaatar, Mongolia

E-mail: yadamjab@yahoo.com

### Annotation

---

The Zahchin Monastery is a continuation of the Oirad Dzungar Kingdom's temples. The Oirad Monastery was first led by Baivgas and all the princes of Oirad took one of their boys to become a monk together with two hundred commoner boys in Tibet to the Dalai Lama and Banchin Bogd and became Buddhists. Among these beginners, the famous nobleman Ravjamba Zaya bandida Namkhajamts, Achit tsorj, Darkhan tsorj, Darjaa gavj, Ravjamba Sodov, and many other wise men appeared in the Oirad region with the teachings of Bogd Zonkhov's modern yellow hat religion, Dalai Lama, and Banchin bogd's book of prophecies. «Oiradyn ikh khüree» was established and the religion was started. Ravjamba Zaya established «Oiradyn ikh khüree» and trained hundreds of disciples, the wise interpreters Agwaanlorojamts, Radnaabadraa, Uyzen nanso, Gunten gavj, Erh tsorj, Sharav gelen, Tarva gavj and Warrior nanso were the leaders. It is recorded in history that Ravjamba Zaya Bandida established the «Oiradyn ikh khüree», branched off from it and founded many monasteries and churches, and carried out major religious and cultural activities in Khalkh, Övörlögch, and Halimag.

### Keywords

---

Zachchin Temple, Ravjamba Zaya bandida, oirad, religion.

## О Р Ш И Л

1662 онд Зая бандида таалал болсны дараа, хутагтын шавь Мэргэн хэлмэрч Агваанлоройжамц, Эрх цорж, Уран хонжин нар Далай ламд айлтган байж, Зая бандидын шавран /хойд дүр/-г тодруулсан боловч, Ойрад нутагтаа залж чадалгүй шавран алдарч одсон тул шавь нар бүгдээр хутагтын шавь нарын манлай хэмээн санал нэгтгэйгээр Мэргэн хэлмэрч Агваанлооройжамцыг Зая бандидын залгамжлагчаар өргөмжилсөн байдаг. Мэргэн хэлмэрчийн олон шавь нараас Лавран хийдийн номын эзэн Гүнчэн лам Жамъяаншадавдорж, Гоман хамба Лувсандунцаг хэмээх эрдэм чадал, алдар нэр хэтийдсэн хоёр шавьгарсан бөгөөд Ноён хамба Лувсанпунцаг Ойрадын хамба сууж Ойрадын шашныг удирдсан байдаг. Энэ гурван их хутагтын шашин барьж байх үед Ойрадад маш олон хийд сүмүүд гарсан ба хамгийн алдартай нь Гулз, Хайнагийн сүм хэмээх бөгөөд Зүүнгарын хаант улсын анги, отгуудад нэлээд олон сүм хийд байснаас гадна Их хурал, Дүлба, Ламрим, Агва, Тосамлин, Жамбалин, Үндсэн, Сандуй, Банчэн хэмээх есэн жас (Далай, 2006) өөрийн гэсэн нутаг, шавь ардуудтай том дацангууд/ байсан нь тэр үеийн шашны хөгжилтийг илтгэж байна.

Ойрад Зүүнгарын олон хаад ноёд ялангуяа Байвгас баатар, Гүшри хаан, Эрдэнэбаатар хун тайж, Галданбошгот хаан, Цэвээнравдан хаан, Галданцэрэн хаан зэрэг их ноёд хууль гаргах, эд хөрөнгөөр туслах зэргээр шашин дэлгэрэх бүх бололцоо нөхцлийг хангаж өгснийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй юм. Ноён хамба Лувсанпунцагын дараа түүний шавь Лувсанцүлтэмринчэн Ойрадын шашныг тэргүүлэн Ойрадын их хүрээ Гулз, Хайнагын сүмд Үндсэн хамбаар суусан байдаг. Ойрадын Үндсэн ламтан Лувсанринчэний тухай “Шашны алтан нарны гэрлийн элч тогтоон өгүүлсэн өлзий цагаан бадам номлол бүтээл өргөн дэлгэр сүмийн эх туурвил алтан эрхи хэмээх оршив”, “Намтар болой, Захчин манай гурван дацангийн Зуу шүтээний намтар оршвой-” зэрэг сурвалжид маш дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Үндсэн ламтан Лувсанренчин 1706 оны гал нохой жил Зүүнгарын хаант улсын хуучин арван хоёр отгийн нэгболох Цоохор отогт мэндэлжээ. Үндсэн ламтныг дөрвөн настай байх цагт, Цоохор отгоос Галданцэрэн хаан авхуулж, тольдон ажиглаад, «энэ надад зөв лам болох» (Дармаабадраа, 2008) хэмээн зарлиг болж ном эрдэмд суралцуулснаар судар, тарнийн ёсонд мэргэжин эш, онолын эрдэм хэтэрхий болсноор Үндсэн ламтан хувилгаан хамба Цүлтэмринчэн хэмээн алдаршиж, Ойрадын шашны тэргүүн болсон юм.

## ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Банчин Лувсан Ишийн гэгээн, Банчин Балдан Ишийн гэгээн хоёр дүрийн бодит шавь, мөн ноён хамбатан Лувсанпунцагийн шавь Үндсэн ламтан Лувсанринчэн Галданцэрэн хааны оройн чимэг лам болж Гулз Хайнагийн сүм, Дүлбаа, Цанид, Жүдба дацангийн нийт түм илүү хуваргыг тэргүүлж байхдаа шагшаа бадийг ариутгасан ба их богдсын бодит шавь мөн тул зарлиг увьдасыг бумба юүлэхүй мэт шавийн чуулганыг боловсруулсан хийгээд тод үсгийн дэлгэрэлтэд анхаарал тавьж, Равжамба Зая бандидийн орчуулга Хутагт судрын аймгийн эрхт хаан дээд Алтангэрэл хэмээх их хөлгөний судар, Хутагт билгийн чанад хүрсэн Таслагч очир хэмээх их хөлгөний судар зэргийг ариутган шүүж хэвт даруулсан зэрэг нэлээд олон том үйлс бүтээсэн нь түүхэнд үлджээ.


1755-1758 онд Зүүнгар манжид эзлэгдэхэд, Зүүнгарын хаант улсын есэн жас, хорь гаруй сүм хийд, 10000 гаруй лам хувраг устаж үгүй болсон бөгөөд үүнээс үлдсэн зургаан хуврагаа дагуулан Үндсэн ламтан Цүлтэмринчэн Зүүнгарын хаант улсаас амьд хоцорсон Захчин отогтой нийлэн Мамууд зайсангийн ач Жанцан гүний шүтээний лам болжээ.


Үндсэн ламтан Цүлтэмринчэн 1756 онд Захчинд ирснийхээ дараа, 1762 оны хар морин жил Захчины Рашигонзэглин хийдийг байгуулахдаа, Далай лам, Банчин богдоос хийдийн шүтээнээр Майдар бурхан, сахиусаар Балдан Лхам бурханыг залж шүтээн, сахиус болгоод, улмаар Гулз Хайнагийн сүмийн ойролцоо нууж үлдээсэн Хутагтын мөнгөн хөрөг дүр тэргүүтэн Ойрадын их хүрээний гол шүтээнийг залж ирээд Хутагтын дацан хэмээн нэрлэж шавь сургах, шашин соёлыг сэргээх нөр их ажлаа дахин эхлүүлсэн байдаг.

1773 онд Захчин Үенчид нүүж ирээд Үенчийн Улаан сүмийг барьсан ба 1778 оны шар нохой жилд хошууг хоёр хуваахад хийд ч мөн хоёр хуваагдан Төгрөгийн хүрээ буюу хоёрдугаар Рашигонзэглин хийдийг байгуулжээ. Ийнхүү шашин амьтны тусыг агуу их зохиогоод 1788 оны шар бичин жил үндсэн ламтан Лувсанренчин 83 сүүдэр дээрээ нирваан дүрийг үзүүлжээ. Захчины ноёд Манжийн хаанаас зөвшөөрөл авч Далай лам, Банчин богдодалтган Үндсэн ламтныхаа дараа дүрүүдийг тодруулан гэгээний ширээнд залж чадсан байна. Захчин гүн Минжүүрдорж Галдан Сэрай Бэрэвүнгийн илт мэдэлтэн, шагжаан гэлэн Агваанжамбалчүлтэмжамц гэгээнтэнд дурьдан 1879 оны шар бар жил Үндсэн ламтан Лувсанчүлтэмринчэн болон түүний дараагийн дөрвөн дүрийн гэгээний алдар оршсон нэгэн залбирал ерөөлийг дээдэст төвд хэлээр зохиолгожээ.

Тэр залбирал нь:

*Баримт 1. Сайн буяны гайхамшигт эх*





Баримт 1. Гэлэг нгомцарма

Сайн буяны гайхамшигт эх эрдэнэ гарахуй орноос  
 Сайтар мэндлэсэн арван хүчний газар баригч эрхтийн дээд  
 Үл эвдэрэхүй дөрөв төгссөн үе зэрэг үзэсгэлэнтэй  
 Үзүүлэгч дээд чадагчийн эрхгийн өлзийг хайрла.  
 Сайн оюут ялгуусны өнө ёсны далайгаас  
 Их эрдэнийн дээдийн номын охь шим чандмань эрдэнийг  
 Алс хязгаарын шавийн цог дор дэлгэрүүлэн зохиогч  
 Цог төгс язгуурын ламдаа залбирамуй.  
 Цастын орны номын тариаланг шинээр ургуулан  
 Асар ариун номлол бүтээлийг барин зохиогч  
 Жич бас Монгол оронд дээдийн номыг  
 Шагшаа бад төгөлдөрөөр тодруулан зохиогч наранд залбирамуй.  
 Хэлний эрх урвуулагч богд ялгуусны  
 Сайн оюут богд зонхавийн шашныг баригч  
 Зөөлөн цогт манзуширийн энэрэхүйг даган баригч  
 Ач төгөлдөр ламын елмийд залбирамуй.  
 Ялгуусны шашныг барин, ивээлийг арвижуулсан хийгээд  
 Маш ид уужим гол онолд айлдлыг машид дэлгэрүүлсэн  
 Өгүүлэгчийн манлай, хэлний эрх баялагт  
 Цог төгөлдөр ламын өлмийд залбирамуй.  
 Шарын шашны титмийг баригч өвөр ёсноос  
 Судар дандар номлол бүтээлийн шашны шимийг авч  
 Хувь сайт шавийг боловсруулан гэтэлгэхүй морд байгуулсан  
 Богд ламын гэгээн өмлий батжих болтугай.

Хуурмаг үгүй дээд гурав ялгуусны адистид хийгээд  
Номын чанарыг үл урвах шүгээн болгосон үнэн хүч  
Сахиусны эрхтийн чуулганы үйлс зохиолоор  
Сэтгэлийн эгээрэл ямарчлан жавхлантай бүтэх болтугай хэмээгч энэ нь

Зүүнгар Алтайн Захчины гүн Минжүүрдорж өөрийн хошууны Рашигонзэглин хийдийн анхны ширээт лам Ренчинчойндантны дөрвөн дүрийн алдар оршсон төвдөөр урихуй залбирал ерөөл хэрэгтэй хэмээн дурьдсаны хариуд Галдансэрай Бэрэвүнгийн илт мэдэлтэн, шагжаан гэлэн Агваанжамбалчүлтэмжамц найруулсан болой” юм.

Энэ залбирал ерөөл нь үндсэн ламтны дараа дүрүүдийн тухай маш чухал баримт болж байна. Үндсэн ламтны дүрүүд нь:

Нэгдүгээр дүрийн Үндсэн ламтан Лувсанринчэн /1706-1788/  
Хоёрдугаар дүрийн Үндсэн ламтан Ринчэнчойндан /1789-1810/  
Гуравдугаар дүрийн Үндсэн ламтан Чүлтэмням /1811-1852/  
Дөрөвдүгээр дүрийн Үндсэн ламтан Агваанлуvsанжамбал /1853-1873/  
Тавдугаар дүрийн Үндсэн ламтан Данзанчанравжамц /1875-?/ нар юм.

Үндсэн ламтны таван дүр болон Захчины ноёд хийгээд олон түмэн 1762-1937 оны хооронд нэгнээсээ салбарлан гарсан Үенч, Төгрөг 1778, Бодонч 1807, Зэрэг 1838, Цагаан бургасны хийд 1864, Рашаатын хүрээ 1906 /Алтан сүмтэй нэг / гэх зургаан хүрээ байгуулж Ойрадын их хүрээний уламжлалыг хадгалж иржээ. Хожим Шинжаанд нүүж очсон Захчингууд 1940 онд Хар-Усаны Хээр дааган гэдэг газар Захчины хүрээ хэмээх Раашдаржаашадрувлин хийдийг байгуулаад, тэндээсээ нүүж, 1944 онд Санжийн их хөдөөтийн хотгор хэмээх газар сүм барьж, Санжийн хүрээ хэмээн нэрлэгдэх болжээ. Тус хийд нь Цогчин, Мамба гэх хоёр дацантай байжээ. Энэ хийдийг Захчины жүн вангийн зэрэг бэйл Дамдинбазар ноён, Үенчийн хүрээний Гэндэн цорж, Зэргийн хүрээний Жалцав да лам тэргүүтэн хүмүүс байгуулсан ба анхны хамбаар нь зэргийн хүрээний Жалцав да лам суужээ. 1958 онд тус хийд хаагджээ.

«Намтар болой, Захчин манай гурван дацангийн Зуу шүтээний намтар оршвой», «Шашны алтан нарны гэрлийн илч тогтоон өгүүлсэн өлзий цагаан бадам номлол бүтээл өргөн дэлгэр сүмийн эх туурвил алтан эрхи хэмээх оршвой» гэдэг хоёр сурвалж бичигт Захчины сүм хийдийн түүх нь маш дэлгэрэнгүй байхаас гадна «Дөрвөдийн баруун гарын үнэн Зоригт ханы аймгийн Захчин хоёр хошууны хүрээ хийд» гэх товч тэмдэглэл, Захчины зурхайч Гүнчин гэсгүйн тэмдэглэл зэрэг тэмдэглэлүүд болон Монгол улсын үндэсний төв архивт Захчины сүм хийдийн үүсэл хөгжлийн талаар зарим мэдээлэл бий. Үүнээс «Намтар болой, Захчин манай гурван дацангийн Зуу шүтээний намтар оршвой», «Дөрвөдийн баруун гарын үнэн Зоригт ханы аймгийн Захчин хоёр хошууны хүрээ хийд» гэх хоёр бичгийг чухалчлан үзэж баримт болгох үүднээс буулгав.

Баримт 2.

Намтар болой. Захчин манай гурван дацангийн зуу шүтээний намтар оршвой.

< 5a > Аяа Ялгуусны оронд эрхшил өгсөн ахмад хөвгүүн итгэл Майдар хэмээгдэх түүний адилын бие, Гуравдугаар шажны Зуу чамд итгэмүй. Шарын шажин өндөртгөхийн шалтгаан болгон шавь өглөгийн эздийн хойдод мэдэхийн гарлага болохын тулд уг язгуурын учирьг тодотгон ер манай Захчин хэмээгч + гүүчүн [гоочун] төгсгөлт хуандийн цагийн илтгэлийн шастирт Захчин хэмээгч харуулын

цэргийн үг зайсан Мамуудад захируулав хэмээсэн бөгөөд мөн < 56 > Зүүнгарын Галдан хан байх цагт анги бүрээс хураагаад арван дайчин болгоод Эрийн хавиргад суулгаж бөх Мамуудад захируулав. Түүнээс Тэнгэр тэтгэсний арванесдүгээр онд модон үхэр жилд (1754) даган орж ирээд гүнгийн хэргэм хүртээд энэ Алтайн газарт нутаглан суув. Одоо гагцхүү Захчин манай шажин дацан тогтсон утга нь анх Тэнгэр тэтгэсний онд манай бүгдийн буян ерөөлийн хүчээр Галдан хааны Үндсэн дацангийн ширээний хамба Үндсэн ламтан Цүлтимринчэний бие залран ирж Ойрадын их цэцэнд алдаршсан Хүнхүй заяач зайсангийн уг итгэмжит бат баатар гүн Жанцаны оройн чимэг лам болон шажин амьтныг жаргуулан суутал Тэнгэр тэтгэсний хоринзургаадугаар оны усан морин жил (1762)-д өглөгийн эзэн гүн Жанцан дурдаж ламтанд мэдүүлэн ер манай Ойрад болвоос богд Зонховын шар шажныг бадруулан тэтгэгч мөний тулд Захчин манай хошууны дотор нэг дацан тогтоон ерөөл гүрмийн <76> ном уншуулж цагаан буяныг дэлгэрүүлэн дэлгэрүүлэе хэмээн мэдүүлэн бас нийтээр зөвшөөд баруун мөнх Зуу, Далай лам, Банчин эрдэнийн гэгээнд айлгасанд сайшааж Балданлхам сахиусны биеийн нууц хөрөг нэг, Рашигонзэглин хэмээх нэр буун соёрхож Ламтанд Шагжамүни, ли жамбасүндэн Майдар, чоддэн /Суварга/ийм адистай шүтээнийг соёрхон ирснээс даруйд Жанцан ч Бүгэнүүд Лувжааг зарж манай дөрвөн Ойрад Зүүнгар <9а> шажныг дэлгэрүүлсэн хутагт Равжамба Зая бандида цорж Намхайжамцын хойд шүтээн мөнгөөр үүдсэн “Дээд цагаан охийн” магтаалт үүнийг Зуу болгон тахиад шарын шажныг дэлгэрүүлж байтал дөчинхоёрдугаар он (1777)-д гүн Жанцан наснаас нөгчсөний хойд дөчингуравдугаар оны шороо нохой жил (1778)-д үйлийн эрхээр Захчин хоёр хошуу болгох цагт дацанг салгаж <96> Зуу болгон Ламтны Жамбасүндэн Майдарыг залж хоёрдугаар Рашигонзэглин дацан хэмээн нэрийдэж шажин амьтны тусыг бүтээв.

Дайчин билэгт хуанди Сайшаалт ерөөлтийн арванхоёрдугаар он гал эм туулай жил (1807)-д гуравдугаар дацан Рашигонзэглин хэмээхийг тогтоож Зуу шүтээнийг нь мөн мөнхүү манай Захчины Равжуул хэмээх хүн ар Халхын Жавзандамба хутагтын гэгээнээс Жамгон /итгэл/ Майдарыг залж Зуу болгон шүтэв. Тэгээд Бүрэнт засагч [32]-ийн зургадугаар он (1867)-ы хаврын тэргүүн <11а> сард залихаа муу иргэнчүүд самуурч тэрсэлсний учирт үнэмлэхүйд бурханы гурван бие үл эвдэрэхүй, янагуухад эвдрэхүй хэмээсэн ёс үзүүлсэнд манай Захчины гүн, үхерида түшмэд, шар хар бүгдээр зөвшилцөж Майдарыг Жавзандамбын гэгээнд хүргэсэнд равниа өргүүлэн өргөл захиа сэлтсийг хамтаар хүргүүлэн бас тус дацангийн гэлэн Цүлтимзонров залах еэчил дун, таван зуун манзийн тогоо хамтад нь бүтээхийн тулд ловон Цамбо, <116> дэмч Равсалын зэрэг хорь илүү хүн зарж явуулсанд долдугаар он [1868]-ы дөрвөн сард Богд Жавзандамбын гэгээнээс гүн надад соёрохсон хишиг зарлигийн дотор зарлиг нь Ховдын Захчины гүн танд амарыг асуун адис зангиа илгээхээс гадна танай дацангийн Зуу Майдар, Дарь эхийг шажин амьтны тусд хичээн амилж, гүсүнтүгийн аль адистай шүтээнийг оршуулав. <13а> Жавзандамба Агванчойжигванчигпэрэнлэйжамц надад сүжиглэгчид бүхэн итгэл Майдар үүнд мөргөх хийгээд эргэх, өргөн хүндлэгчид бүгд гурван хорын зэтгэр арилаад, гурван муу заяатнаас гэтэлж, ирээдүй Майдар лугаа учрах бөгөөд танай шажин өнөд дэлгэрэх болмуй. Үүнийг поврон Дэчэнгалав хэмээсэн бөгөөд үүний хамтад Гонхор бүрэлгүү Жамдоо хамбын захиа дотор нь дээдийн эш зарлиг, Гонгорын бумбыг явуулснаас гадна еэчил дун, <136> манзийн тогоо, бас Гэндэнрүвийн хүрд дацан бүрд нижгээд бүтээж явуулсныг мэдэгдэн бас шажин хийгээд өглөгийн эзэд та бүгдийн аливаа үйлс бүтэх

болтугай хэмээн хүргэн ирсэн буй. Одоо Итгэл Майдарын гэгээнийг залж ман бүгдийг мөргүүлэхийн тул залсан үүний амьтныг жаргуулагч шажныг мандуулагч богд Жавзандамбын зарлигийн эшийг гүний тамгад хураасныг тодорхойлон манай Захчин шар, хар бүгдэд үнэлэхийн тулд <15а> монгол үсгээр бичиж үхэридаагийн тамга дарсан тэмдэг болгож үхэридаагийн тамгын газар хадгалан хойшид тэмдэг болгон бас ч Захчины гурван дацангийн хуврагууд та бүхэн эх хөвгүүн, лам шавийн ёсоор амьтны тус үйлдээд ялангуяа Захчин бидний эв найрыг зохион зохилдохуйн шалтгаан төгсгөн хэрүүл тэмцлийг огоот тэвчиж гээгээд, харшлахын шалтгаан арилгахуйг хоёр ёсоор айлд хэмээхээс бас манай дацангийн <15б> гагц эзэн лам Үндсэн хувилгаан Цүлтимринчэн, тойн Цүлтимням, Агван Лувсанжамбал эдэн “төрлийн үесийг огоот барьсан зарлигийн ачит лам” мөний тул лам юугаа “Ламын тавин шүлэгт”-ийн ёсоор ачлан хүнлэх хэрэгтэй буй хэмээх үүнийг Ховдын харъяат Захчины үхэрида Сүх хэмээх бээр шажин амьтны оюун зохилдохыг эрхэмлэн санаж алгаа хамтатган сөгдөн сүзэглэн айлдхав.

<17а> Шарын шажин арван зүгт дэлгэрээд, өглөгийн эздийн санасан бүтээд, эрдэм нүгүүд бүтэх болтугай.

Дайчин улсын Бүрэнт засагчийн наймдугаар он арвантавдугаар равжун [42] шороо эм могой жил (1869)-ийн зуны сүүл сарын хорин наймны маш баясгалант дээд түмэн өлзий бүрдсэн түгээмэл гэрэл бадарсан цог учралт сайн өдөр төгсөв.

<17б> Бичээч нь хүнд бошго Нямдэлэг болой.

Захчин манай дацангийн Зуу шүтээний намтар үзэх дурлагчид нь шүтээний утга нь хутагтын тууж “Сарын гэрэл” [46]-д, Майдар Жамбасүндэний /Асрахуй, зарлиг төгс шүтээн Майдар/ утга нь ламтны санд буй. Итгэл Майдарын утга нь гүний тамгын газарт буй амуй.

Баримт 3.

Дөрвөдийн баруун гарын үнэн Зоригт ханы аймгийн Захчин хоёр хошууны хүрээ хийд

«Арван гуравдугаар жарны модон нохой жил Тэнгэр тэтгэсний арван есдүгээр /1954/ онд Захчины тэргүүн Мамууд шажинд оров. Түүнээс хойш есэн жил болоод усан морин жил Тэнгэр тэтгэсний хорин долдугаар он /1762/-д Гурван шар жаргалант хэмээх газар зуны эхэн сарын 15-ны сайн өдөр Зүүнгарын үндсэн хамба Цүлтимринчэн лам, Сайхан Чоомбо, Хар Харзуй умзад, гэлэн Лэгрүв нарын долоон лам анхны жанга /харанга/ цохиж хурал тогтоон таван жил болсны хойно гал гахай жил Тэнгэрийн тэтгэсний 32 дугаар /1767/ онд гэлэн Лэгрүв шар хар олон нийтээр зөвшин явж Үй, Зангийн газар Далай лам, Банчин эрдэнэ хоёрт айлтгаж машид сайшаагдав.

Шороон нохой жил тэнгэр тэтгэсний 43-р онд /1778/ Жанаваг да ноёны үед Төгрөгийн Содномдаржаа Рашигонзэглин дацан тогтов. Үүнээс хойш хорин есөн жил өнгөрөөд гал туулай жил Сайшаалт Ерөөлтийн 12 он /1807/-д Бодончийн дацан тогтов. Үүнээс хойш гучин нэгэн жил өнгөрөөд шороон нохой жил Төр гэрэлтийн 18-р он /1838/-д Зэрэгийн дацан тогтов. Үүнээс хойш хорин зургаан жил өнгөрөөд модон хулгана жил Бүрэнт засагчийн гуравдугаар он /1864/-д Цагаан бургасны дацан тогтов. Захчины анх 1762 онд байгуулсан дацныг анх дацан буюу “Хутагтын дацан” гэдэг. Гулз, Хайнагийн сүмийн буурь хавиас Тэнгэр тэтгэгчийн гучин хоёрдугар он /1767/-д олдсон Зая Бандида хутагтын мөнгөн хөргийг авч бурхан болгон шүтснээр

ийнхүү “Хутагтын дацан” хэмээжээ. Энэ хүрээ анх үүссэн Гурван шар жаргалан-таас нүүж Үенчийн Улаан эрэг хэмээх газар суурьшихад Жанцан гүн өглөгийн эзэн болж анхны дуганыг байгуулжээ. Бадаргуулт төрийн дөрөвдүгээр он /1878/-д Захчины нэгэн хошуу хоёр хошуу болж салахад Хутагтын дацангаас Төгрөгийн дацан тусгаар болж гарав. Урьд баруун Зуугийн газраас залж ирсэн Ли жамбасүндэн Майдарыг гол шүтээн болгож тахиулснаар Содномдаржаа Раашгонзэглин дацан хэмээжээ. Төгрөг хэмээх газар суурилжээ. Зэрэгийн дацан нь Төгрөгийн хүрээнээс тасарч Зэрэгийн голын хойд эхэнд суурьшив. Зэрэгийн хүрээ нь богд Жавзандамба хутагтаас сандулэн Майдар бурхан залж шүтээний гол болгон тахиад дацан хүрээгээ гуравдахь Рашигонзэглин дацан хэмээв. Тонхилын хүрээнээс цамын дэг авч анх цам бүжиг гаргажээ. Цагаан бургасны дацанг Эргийн усанд тогтоож Лхам бурханыг гол шүтээн болгож тахих болжээ. Энэ дацанг Улиастай дацан гэж өөр /өөрөөр/ нэрлэдэг байв. Энэ хүрээнд чойр хурна. Мөн цам гардаг байв. Бас Рашаантын хурал гэж байв. Хайлан хурдаг хурал байв.

Энэ хоёр баримтаас 1762-1900 оны эхэн үе хүртэлх Захчины сүм хийдийн түүх ерөнхийдөө харагдана. Судлаачид Төгрөгийн хүрээний лам хуврагын тоог 350, Зэрэгийн хүрээний лам, хуварга 300 гэх мэтээр тэмдэглэдэг. Энэ нь архивын баримтад тулгуурлан гаргасан тоо юм.

Харин аман мэдээгээр бол манай өвгөн багш нар Төгрөгийн хүрээ 500 шавьтай, Зэрэгийн хүрээ 1500 шавьтай, Бургасны хүрээг 200 орчим ламтай байсан гэж хэлдэг. Өвгөчүүл бидэнд хэлэхдээ хийд орон хамгийн олон ламтай байснаа хэлдэг бол баримтад хамгийн цөөн болсон үеийг хэлжээ. Энэ яагаад ийм зөрүүтэй байна гэхээр 1921 оноос эхэлсэн ардын хувьсгал нь сүүлдээ ангийн ялгаа гарч төрийн хуулиар шашныг бууруулах бодлого барьж эцэстээ шашингүй болгосон байдаг. Энэ бодлого нь элдэв татварын дарамтаар эхэлж эцэстээ хэлмэгдүүлэн, буудан алж, хөрөнгийг хурааж, сүм хийдийг төрийн хуулиар үйл ажиллагааг нь зогсоосон юм. 1921-1937 он хүртэл явагдсан энэ бодлогын үр дүнд 1500 ламтай байсан Зэрэгийн хүрээний баян лам нар ядуурсан бол ядуу лам нар татвар төлж чадахгүйн эрхэнд хүчээр хар болж амь зуусан байна. Хийдийн зарим лам нар гадагшаа дүрвэн гарчээ. Хийдэд сууж байсан шавь нар цаашид суралцахаа больж нэмж хийдэд шавилан суух хүүхэдгүй болсон зэргээс шалтгаалан хэдхэн жилийн дотор 1500-аас 300 болтлоо буурсан байна.

Уг нь Зэрэгийн хүрээ нь захчин хоёр хошууны хамгийн олон шавьтай хүрээ байсан билээ. 1920-иод онд үндсэн ламтан Чүлтэмрэнчин таалал болсны дараа төрийн хуулиар хутагт хувилгаадыг тодруулахыг хориглосноос болж гэгээний дүрийг тодруулах явдал тасалдаж хошууны хамгийн том хийд болох Зэрэгийн хүрээний хамбад шашны эрх шилжсэн байдаг. 1925 онд захчин хоёр хошуу нэгдэж Ханбаатар хайрхан уулын хошуу болоход хошууны шашны хэрэг эрхлэх газрын тэмдэг гэсэн тамгыг Зэрэгийн хүрээний хамбад олгожээ. Энэ үед Зэргийн хүрээний хамбаар Балжинням, Зодов нар дараалан суусан ба Бодончийн хүрээг Арваг да лам, Төгрөгийн хүрээг Хорлоо ловон ахалж байжээ. Эдгээр хүрээний ахлаач лам нар хэдийгээр хүрээгээ ахлах боловч Захчины хүрээ хийдүүдийн шашин төрийн аливаа том хэрэг явдлыг Зэргийн хүрээний хамба хамаарч байжээ. Хүрээ хийдүүд зунд нэгдэн чуулж хошууны төв болох Ангиртын бэлчирт хүрээлж буугаад зуны

хурал хайлан, хошуу их даллага болон сургалтын үйл явуулдаг байсан ба “лам нарын буурь” хэмээх том ул мөр одоо Манхан сумын нутаг Ангиртын бэлчрийн Улаан толгойн ард байдаг.

Зэрэгийн хүрээний хамбын тамгыг 1937 онд хийд хаагдахад гэлэн, гэвш П. игмэд ламтан 31 насандаа өөр нэгэн ламын хамтаар аймгийн захиргаанд тушааж байсан гэдэг.

1990 онд Раашгонзэглэн хийд Манхан суманд дахин байгуулагдахад П. Жигмэд 84 насандаа хамбын ширээнд суусан ба аймгийн музейд хадгалагдаж байсан хуучин тамгаа эргүүлж аваад “Олон жилийн өмнө би хүргэж засагт тушааж байсан, өнөөдөр дахин сэргээх тавилан ерөөлтэй байжээ” гэж хэлээд тэргүүндээ хүргэн адис хүртэж байсан гэдэг.

1990 оны 11 сард Төгрөгийн хүрээ дахин сэргэхэд П. Жигмэд хамба лам, Ш. Донров ловон лам, Ө. Еэшээ умзад лам, О. Бүрэлгүү хурлын лам, Т. Санжаа хурлын лам, Т. Сунгарав хурлын лам, Ц. Равдан хурлын лам, Г. Бадам тахилч лам болсон ба мөн жилийн 12 сард 35 хүүхэд авч нэг анги болгон умзад лам Ө. Еэшээ багш ном зааж эхэлсэн юм. Эдгээр хүүхдүүдээс 12 нь сахил хүртэж лам болсон. Энэхүү хүүхдүүдээс хийддээ үлдэж сургууль дүүргэсэн дөрвөн лам нь Г. Ядамжав, Т. Сэргэлэн, Ц. Хүрэлсүм, Д. Тэгшжаргал нар бүгдээрээ их сургууль төгсөж боловсролтой лам нар болсон. Бусад хүүхдүүд цагийн эрхээр өөр ажил мэргэжил сонгосон ч үнэнч сүсэгтнүүд болсон байдаг.

1995 онд лам болсон Г. Цэгмид лам, 2000 оноос лам болсон С. Тагтааням хоёр хэдийгээр их сургуульд суралцаагүй боловч үздэг, уншдаг, үлээдэг, тарниддаг таван шид бүрдсэн нутаг усандаа нэртэй сайн лам нар юм. Хоёр ах лам маань хийддээ сууж буяны үйл эрхлэнхэн, сүсэгтэн олон түмэндээ үйлчилж байна. 1991 онд П. Жигмэд хамба таалал болсноос хойш хамбын суудалд хэнч суугаагүй бөгөөд хамбын дараачын тушаал болох ловон лам хийд орныг удирдан байдаг ба хамбын ширээнд эдлэл хэрэглэл, зул дээж өргөж хүндэтгэн тахиж байгаа болно.

Бид зургаа хийдийнхээ хурал номыг таслалгүй хурж шавь сургаж, сүсэгтэн олонд буян ном үйлдэх, боломжийн хэрээр судар ном хэвлэх, гадаад дотоодын шашны болоод эрдэм шинжилгээний хуралд оролцох зэрэг ажлыг хийж байна.

Манай шавь нараас П. Жигмэд хамбын зээ хүү В. Ганбилэг Энэтхэгийн Сэра хийдэд шашны боловсрол эзэмшиж байна.

Тус хийд 1990 онд анх Ардын депутатуудын хурлын танхимд цуглаж хурлаа сэргээгээд тэр хавраа хашаа татаж гэр дуганд хурлаа хурж байгаад 1994 онд Манхан сумын засаг дарга С. Дамдинсүрэн, Рашигонзэглин хийдийн ловон лам Ш. Доноров тэргүүлж сүсэгтэн олон түмний дэмжлэгтэйгээр шавар, модон бүтэцтэй шинэ дуган хийд барьж байгуулан хурах болсон. 2011 онд Манхан сумын засаг дарга С. Гантөмөр, тус хийдийн ловон Г. Ядамжав нар санаачлан хүсэлт тавьснаар Г. Мөнхбаяр ахлаачтай тус сумын Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлөөс шинээр маш сайхан сүм байгуулан Гүмбэн хийдээс 5 тохой өндөр Алтан Майдар, тохой өндөр Алтан Майдар тэргүүтэн шүтээнийг шинээр залж Зүүн хүрээ Дашчойлон хийдийн хамба лам Дамбажав, Ганданпунцагчойлин хийдийн хамба Самбуу тэргүүтэй лам хуврагуудаар хийд, шүтээнд равнай өргүүлэн, өргөн дэлгэр наадам хийж ёслол төгөлдөр Рашигонзэглин хийдэд хүлээлгэн өгсөн юм.

Энэ хийд маань орчин үеийн шаардлагад нийцсэн маш чанар үзэмжтэй бөгөөд гадаад, дотоодын сүсэгтнүүд, судлаачдын талархалыг хүлээсэн, сонирхолтой олон өв, уламжлалыг хадгалсан сайхан хийд байдаг.

Төрийн бодлого тодорхой биш зэргээс шалтгаалж өнөөгийн Монголын нийт сүм хийдийн хөгжилт удаан, саармаг шинжтэй байгааг тэмдэглэе.

### **Захчины сүм хийдийн уламжлалт хурал уншлага**

Манай өвгөн багш нарын гурав нь Зэрэгийн хүрээний шавь, тав нь Төгрөгийн хүрээний шавь байсан боловч хурлын уншлага, ном судар нь яв цав таарч тохирч яг л нэг янзаар уншдаг байсан билээ. Багш нар маань бүгд бүрэн сайхан номтойбайлаа. Шавь биднийг уншиж сурсны дараа хурлын бүрэн судар ном тараан өгсөн билээ.

Хийдийн гол хурлууд нь: Гүүдрийн хурал буюу 10 хангал (билгийн улирлын 12-р сарын 23-30 хүртэл)

23-нд Гүүдрийн суурь хурал (Үргэлжийн хурлаас хэсэгчлэн унших, тахил балин бэлдэх)

24-нд Арван хангал (Жигжэд, Гомбо, Гонгор, Чойжоо, Лхам, Шалши, Намсрай, Жамсран, Алтай жалва, Хахур)

25-нд Гонча лха сүм буюу 5 их хангал (Жигжэд, Гомбо, Гонгор, Чойжоо, Лхам)

26-нд Таван бага хангал (Шалши, Намсрай, Жамсран, Алтай жалва, Хахур)

27-нд Гонча лха сүм буюу 5 их хангал (Жигжэд, Гомбо, Гонгор, Чойжоо, Лхам)

28-нд Таван бага хангал (Шалши, Намсрай, Жамсран, Алтай жалва, Хахур)

29-нд Гонча лха сүм буюу 5 их хангал (Жигжэд, Гомбо, Гонгор, Чойжоо, Лхам)

30-нд Арван хангал (Жигжэд, Гомбо, Гонгор, Чойжоо, Лхам, Шалши, Намсрай, Жамсран, Алтай жалва, Хахур).

30-нд Их ерөөлийн суурь уншина (Үргэлжийн хур хурлаас хэсэгчлэн унших).

30-ны шөнө лхамын хурал (Жигжэд, Лхам, Лхамын цэдор).

Чойнпрүлжүна буюу Их ерөөлийн хурал(Хаврын шинийн 3-аас 15 хүртэл).

Шинийн нэгний өглөө эрт овоонд очиж их сан, сэржим, цацал өргөнө.

03-8-нд Их ерөөл хурна.

8-15-нд Их ерөөл чангарч /нэмэлттэй/хурна

15 үргэлжийн хурлын суурь(Үргэлжийн хур хурлаас хэсэгчлэн унших)

15-нд Майдар эргэнэ.

16-аас эхлэн Үргэлжийн хурал

Зуны адаг сарын 15-нд хошуу их даллага авна.

Өвлийн эхэн сарын 20-оос 25-нд намчидын хурал буюу ерөөлийн хурал.

20-нд Ерөөлийн хурлын суурь (Үргэлжийн хур хурлаас хэсэгчлэн унших).

21-24-нд Ерөөл хурна.

25-нд Ерөөл хурна “шар ганри уншиж, орой зул барина”.

Сар бүрийн 8, 15-нд үргэлжийн хурал дээр нэмж манал, цанжид уншдаг.

Сар бүрийн 13-нд үргэлжийн хуралд дээр нэмж Равжамжалба уншдаг.

Сар бүрийн 22-нд үргэлжийн хурал дээр нэмж Манал, Цанжид, Цагаан шүхэрт, Таван ерөөл, Ламрим дүйдан, Ламын чодба уншдаг.


Сар бүрийн 29-нд Арван хангал хурна.(Жигжэд, Гомбо, Гонгор, Чойжоо, Лхам, Шалши, Намсрай, Жамсран, Алтай жалва, Хахур )

Зуны сард нутгийн шүтээн уул овооны тахилга хийдэг.

Эдгээр хурлын уншлагаас гурван судрыг баримт болгон бага зэрэг тайлбарлан үзүүлэе.

Баримт 4.

Магтаал ерөөл, ерөөл, чойжингууд бүгдийн гарчиг шүгсо (оршвой).



Үзүг, жамдэй, гавсум ма, найдан чагчод, дором жаза, савян чэнба, балдан сасум, гандан лхавжа, түвван ма, солдэв, лувсан жалва, дамхай дарян, пунцаг гүсүм, жинлав ма, дамцаг доржийн дайв, дүншаг, санжод, санжаа гүнла, ширнэн, сан, жавзан оролма, оролгар, каням, лочэн ма, цэван ма, суа ва, нишин ма, шэсол ва, ран няд гаджиг, дором пүл, жалва малу, данбар ма, дугар, часум, дүдүм, чодвий, чоҗжү жалва, пүлжүн ма, гэва дэей, дагги жанчүв, жамба ма, сан ва намтар, лэгбрэ ма, сэндэн ма, рэн ба няммэд, шэжа каян, цанжод, манал, гайрин солдэв, дагшин намхай, дэнбэрэл додов, жачэн цогни, ламрим солдэв, их ерөөл.

Лажүд солдэв, балдорж жигжэд, гонбо, гонгор, хахухри, дамжин чойжал, додхам ванчиг, балгон шалши, жалва чэнбо намтосрэ, чойжин жамсран, алтай жалва, лхүнрэв дэва, лама лажүн, ёншин, нгачэн, чойжил сор, цэжиг лхамд дорпүл ма.

Брүл (могой) жилийн тэргүүн сарын шинийн нэгэнд эхлээд гурван сарын хорин хоёронд төгсөөв. 64 эхтэй 309 цаасан ном буй.


Тайлбар: Энэ судар нь Рашигонзэглин хийдийн номын сангийн ном дотроос гарсан 9смХ44см хэмжээтэй 2 хуудас ном юм. 1а хуудсанд нэг мөрөнд “Магтаал ерөөл, ерөөл, чойжингүүд бүгдийн гарчиг шүгсо (оршвой)” гэж бичсэн, 1б, 2а хуудсанд таван мөрөөр “Үзэг...309 цаасан ном буй” гэж бичсэнба 2б хуудас хоосон. Энэ хоёр хуудас ном нь Раашгонзэглин хийдийн Цогчэн дацангийн хурал уншлагын гарчиг болох ба маш их мэдээлэл агуулж, олон талын судалгаанд баримт болохоор, олон асуултанд хариулт өгөхөөр бас олон асуулт нэхэхээр сонирхолтой бөгөөд өндөр ач холбогдолтой баримт юм. Захчины хүрээ хийдүүд чухам ямар ном уншиж байсан, хэдэн ном уншиж байсан, ямар бурхан шүтээнд, аль богд дээдэст залбирч мөргөдөг байсан, ямар догшидхангалыг тахиж байсан, сор залдагуу, шинийн нэгэнд лхамын дором өргөдүү, үнэхээр Зая бандидын магтаал уншиж байж уу гэх мэт олон асуултанд маш тодорхой “энэ, тийм, тэдэн” гэсэн хариулт өгч чадаж байна. Эргээд биднээс аль могой жилд бичигдсэн,хэдэн онд, хэн бичсэн , 309 хуудас ном нь одоо хаана байдаг бол, “үргэлжийн хурлын 62” гэдэг байтал энд яагаад 64 эхтэй

ном болов, ямар хоёр ном нэмэгдэж оров, бусад хүрээ хийдийн хурал уншлага хэдэн эхтэй байдаг бол гэх мэт олон асуулт нэхэж байгаа. Энэ талыг тодруулах, харьцуулах хэрэгтэй байна. Харамсалтай нь бусад хүрээ хийдүүдээс энэ мэт гарчиг болон бүрэн уншлагын ном судар гарч ирэх нь тун бүрхэг болсон буюу одоогоор Увс, Баян-өлгий аймгийн хийдүүд, Ховд аймгийн бусад хийдүүдэд яг энэ мэт баримт байхгүй байна. Түүнчлэн БНХАУ-ын Шинжааны Уйгар өөртөө засах орны хийдүүд, Халимагийн хийдүүдийн бүрэн уншлага тодорхой мэдэгдэж өгөхгүй бүрхэг бүдэг байна. БНХАУ-ын Хөхнуурын Хошууд Дээд монголчуудын зарим хийд, дацангуудын лам хуврагууд Зая бандидын солдэв магтаал унших нь байтугай Зая бандидаг сайн мэдэхгүй байгаа нь санаа зовоосон нэг асуудал болж байна. Төрийн бодлого, хууль тодорхой биш зэргээс шалтгаалж өнөөгийн Монголын нийт сүм хийдийн хөгжилт удаан, саармаг шинжтэй байгааг тэмдэглэе.


Анх Ойрадад шашин дэлгэрэх цагт Ойрадын их хүрээнээс Ойрадын бусад хүрээ хийдүүд салбарлан гарсан хожим Үндсэн ламтан Захчинд ирээд Раашгонзэглин хийдийг байгуулаад түүнээс салбарлан Захчины бусад хүрээ хийдүүд үүсэн бий болсон байдаг. Үүнээс дүгнэлт хийж нэг хийдээс нөгөө хийдүүд салбарлан гардаг гэж үзвэл манай Ойрадын хийдүүд шүтээн, уншлага нэг гэж үзэх бүрэн үндэстэйн дээр өөрийн хийдэдшинээр хутагт гэгээн тодруулснаас ганц нэг магтаал солдэв нэмэгдэх тохиолдолд хийдийн хурал уншлагадаа нэмээд уншиж болох харин Захчины хийдэд уншигдах Зая бандидын солдэв «Огторгуй мэт уужим эх», Үндсэн ламтан хувилгаан хамба Цүлтимринчэний солдэв «Сайн буяны гайхамшигт эх» хэмээх энэ хоёр залбирал нь Ойрадын шашны эзэн, шашныг баригч хоёр их хутагтын залбирал тул Ойрадын гэх тодотголтой бүх хийдүүд өдөр тутмын уншлагадаа оруулж унших, энэ хоёр гэгээнтний хөрөг дүрийг залж шүтэх нь их хэрэгтэй буянтай хэрэг юм. Цаашдаа шашныг баригч Мэргэн хэлмэрч Агваанлоорой гэгээнтэн болон Ноён хамба Лувсанпунцаг гэгээнтэнэнэ хоёр хутагтын солдэв залбирлыг олж унших, энэ гэгээнтнүүдийн талаар тодруулах судлах хэрэгтэй байна. Энэ гарчигт буй бас нэг онцлогтой ном нь «Алтай жалва» буюу Алтайн хаан хэмээх хангал юм. Энэ сахиус нь мөн Захчины номт нарын нэг гэвш, гэлэн Самдан лам Банчэн богд Лувсанбалдандамбийнямчогланамжалбалсамбууд дурьдан байж тахилгын ном зохиолгож улмаар шүтээн зургийг нь бүтээж 10 дошгин сахиус Чойжингийнхоо нэг болгосон байна. Энэ Алтай жалва судрыг Алтайн Урианхайн Рашчойлин хийдэд бард бүтээж түгээгээд мөн Алтайн Урианхайн хийдүүдэд 10 хангалын нэгээр шүтэн уншлага тахилгыг нь хийж байсан баримт бий.

#### Баримт 5.

Намхайдарянма. Раашгонзэглин хийдийн төвд эх, орчуулга  
ОГТОРГУЙ МЭТ АГУУ ЭХ ОРШИВАЙ



[illegible][illegible][illegible][illegible][illegible]



Баримт 2. “Намхайдаряна” Манханаас олдсон эх

Ламд мөргөмүй!

Огторгуй мэт агуу уужим билгийн онгоц салаар зорчиж  
Онолтойяа судар, тарнийн ухааны эрдмийн далайн чанад хязгаараас  
Олон амьтныг гэтэлгэхүй ашидын амгалангийн сайн эрдэнийг олж  
Ойрад түмэнд шашныг дэлгэсэн дээд сартваахи багшдаа залбирмуй.  
Эрдмийн ачлал дөрөв лүгээ төгс шажнаа орохуй үүдийг  
Эндүүрэл үгүй сонсох, сэтгэхүйн агуу их түлхүүрээр нээж  
Эх хэлээр дээдийн номын хаан төрд орчуулгыг зохиосон  
Эгнэшгүй мэргэн, ариун, сайн багш тацдаа сөгдөн залбирмуй.  
Огторгуй мэт агуу их огт хязгааргүй номлолыг хайрласан  
Онол шинжлэл төгс Эрдэнийн садан багшийг даган одохуй  
Олныг сонссон өдөр боллогч таны гэгээн бусад мэргэдийг  
Онгирсон өвсний галт хорхой мэт болгон зохиогчид залбирмуй.  
Өөрийн амгаланг анхааран авахуй доод мерийн амрахуй орныг  
Үнэхээр боомтлон, буйд уужим хязгаар орны гүрэн улсад  
Үнс болон унтарсан шажин амьтны жаргаланг дахин бадамлуулахуй  
Үлэмж их бадааст явддыг туурвин зохиогчид бишрэн залбирмуй.  
Эрхэм шүнгийн гол ёсыг олонтоо сонссоны тул мэргэн  
Энэ лагшны үндсээ сэргэмжийн цаазаар номхотгосны тул ариун  
Элдвээр алагчилал үгүй амьтныг тэгшид энэрсэний тул сайн  
Эгнэш үгүй дээд богдсын намтар баригч танд залбирмуй.  
Өглөг, шагшаабад, хүлцэнгүй, хичээнгүй, самади, билгийн зургаан барамдаар  
Өөрийн үндэс сайтар боловсорсон үр жимсний үүрэг хүнддэн  
Үнэхээр сайтар хураахуй дөрвөн бодиор шавь нарын чуулганыг  
Өнгөт ертөнцөөс гэтэлгэн сайн орноо туурвин зохиогчид залбирмуй.  
Абшиг эш дөрвийн тоосон давхарласан элэнц хуланцын мөрнөөс  
Арвин гүн мөр үүсгэл, төгсгөлийн Ганга мөрний үргэлжлэлийг  
Ариун хослон орохуй далайд буулган үйлдэхүй илбийн аргач  
Авралт буяны багш садан төгс хувьтны тэргэнд залбирмуй.  
Огторгуйн хязгаар мэт хэмжин барихуйяа маш бэрх болсон  
Оломгүй далай мэт гүн эх болсон амьтны хэргийг  
Оройн дээд итгэл таны гайхамшигтай төрлийн үйлс нүгүүд  
Одоо би тэргүүтэн шавь нарын хэрэгт дэлгэрэх болтугай.  
Ариун цагаан ерөөл тавьсан эрхт хүчин төгссөн бээр  
Арилсан дээд орны амьтныг удирдан хөтлөгч энэ сартваахи  
Ариун номын үүднээ эл шарыг асаан бүжиглэн цэнгэгч  
Амьтны үр садан болон хувилгаан лагшин зохиогчид залбирмуй.

88

Намо гүрү  
Огторгуй мэт агуу билгийн онгоц салаар  
Судар, үндэс сайн зарлигийн далайн чанад хязгаараас  
Маш гэтлэн ашидын амгалангийн маани сайтар олсон  
Буяны садан дээд удирдагч ноёндзалбирмуй  
Дөрвөн их төгссөн шажинд орохуйн үүд  
Эндүүрэл үгүй сонсох сэтгэхүйн агуу их түлхүүрээр нээн  
Дээд номын хаан оронд эрхшээл орчуулагч  
Мэргэн тойн сайн дор залбирмуй  
Маш агуу мэдлэгийн оронд хязгааргүй  
Сайн онолт Ег садны өлмийн хойноос даган явахуй  
Олныг сонссонөдөр боллогччиний гэгээн  
Бус мэргэдийг галт хорхой мэт болгон үйлдэгчид залбирмуй  
Өөрийн амгаланг зөв авч доорд мөрт амухуй орныг  
Сайтар тэвчиж, хязгаар хөшүүн муу оронд  
Шашин амьтны амгалан жаргалангийн унтарсан галыг сайтар шатаахуй  
Их бардаатай явдал үйлдэгчид залбирмуй  
Гол ёсыг олонтоо сонсон сэтгэхүйн тулмэргэн  
Өөрийн үндэс төв сэрэлтийн засгаар номхотгосны тул тойвор  
Алагчлалгүй амьтанд тэгш энэрэхүйн тул сайн  
Дээдсийн тууж баригчид залбирмуй  
Өглөг, шагшаабад, хүлцэнгүй, хичээнгүй, самади, билигээр  
Өөрийн үндэс сайтар боловсрон үрийн үүрэг хүнддэн  
Хураахуй дөрвөн бодиор номхотголгын чуулганыг  
Сайтар гэтэлгэн үйлдэгчид залбирмуй  
Дөрвөн авшгийн тоосон давхарласан өвөгийн ус мөрнөөс  
Гүн мөр үүсгэл, төгсгөлийн Гангын үргэлжлэлийг  
Хошлон орохуй далайд буулган үйлдэхүй илбийн аргач  
Буяны садан төгс хувьтаны тэргэнд залбирмуй  
/Биеийн төрөл хувиан залрахын ерөөл/  
Огторгуйн хязгаар мэт хэмжилд барих бэрх  
Далай мэт гүн эх болсон амьтны тулд  
Итгэлт чиний гайхамшигт төрлийн үеүүд  
Би тэргүүтэн номхотголгын тул хувиан үтэр үзэгдэх болтугай  
Үндэс, үндэслэсэн лам ядам мандалын бурхан  
Баатар дагина тангарагт сахиулсаны чуулган  
Дээд гурван эрдэнийн нигүүлсэхүйн адистаар  
Ерөөл сайтар талбисан ямарчлан бүтэх болтугай  
Цагаан зүг таалагч тэнгэр хийгээд арш тэнгэр  
Үг хийгээд тамлахуйд эрхшээсний үнэн үг хийгээд  
Би тэргүүтнийг засдаг бус үнэн сэтгэлээр  
Залбирсаны үр жавхлантай бүтэх болтугай  
Өдгөөгөөс тэргүүлж үл оршихуй нирвааны  
Их газар илэрхий эс болсон тэжээд

Огоот баригч лам даган шадар бариад

Тус амгалангийн цогт эдлэхүйеэ намайг адистидла.

хэмээн Цэцэн цорж Намхайжамцад залбирахуй хийгээд биеийн төрөл өөд болохуй, ерөөл лүгээ сэлт нэгэн хэрэгтэй хэмээн их буяны нөхөр садан Гоман ловон сүрба Агваанбалжир хийгээд Гүнтан гавж Лувсан эхлэн, мөн Цорж түүний шавь нарын дурсанд шүтэж Сахорын бандид найруулсан бичээч нь шинэ оронт Жамьян буй.

Тайлбар: Энд Равжамба Зая бандида Намхайжамц хутагтын магтаал “Намхай дарялма” -ийн Рашигонзэглин хийдийн хурлын уншлаган дахь төвд эх болон Урианхайн Раашчойлон хийдийн Х. Бямбажав ламтаны судалгаагаар илэрсэн V Далай лам Лувсанжамцын бүрэн сүмбүм дотроос гарсан төвд эх хоёрыг харьцуулан орчуулгын хамт үзүүлэв. Раашгонзэглин хийдийн эх сударнь 12 шүлэг, V Далай ламын сүмбүмээс гарсан эх судар нь 11 шүлэг байна. Жич Манхан сумаас олдсон тод үсгийн “Равжамба Заябандидын тууж сарны гэрэл хэмээх оршив” хэмээх эхийн дотор энэ залбирал тод үсгээр байх бөгөөд 11 шүлэг буй (Раднаабадраа, 2009).

Бурханы арван хоёр зохионгуй гэж байдаг ба Далай лам магтаалаа зохиохдоо үүнийг баримтлан 12 шүлэг зохиосон нь маш тодорхой зүйл. Ингэхээр Далай ламын сүмбүм буюу бүрэн зохиолд буй эх болон тод үсгийн намтаръямар нэг шалтгаанаар нэг шүлэг тасарсан буюу дутсан байна. Энэхүү Раашгонзэглин хийдийн төвд эх нь Зая бандидын магтаалыг бүрэн болгож, Далай ламын зарлигийг бүтэн болгосноороо шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой ба цаашид судлаачид хэрэглэхдээ энэ 12 шүлэгтэй бүрэн эхийг барьж, хэрэглэж байх нь зүйтэй юм. Энэ өгүүлэн буй хурал уншлага нь Раашгонзэглин хийдийн “Цогчэн дацан” буюу Их хурал дацангийн уншлага болно. Тус хийдэд дээр дурьдснаас гадна маш олон төвд, тод судрууд болон Жүд дацан, Дүнхэр дацан, Цанид дацан гэх бусад дацангийн уншлагууд судлах эзнээ хүлээн бүрнээрээ хадгалагдаж байна.

## ДҮГНЭЛТ

Уламжлалт шашин номын болоод түүхийн өв соёлыг хадгалан хамгаалж, цагийн хэцүү, төрийн хатуу хуулийг сөрөн байж, амь насаа дэнчин тавьж, багш дээдсийнхээ зарлигийн алдалгүй дагаж, өнөө үеийн бидэнд өвлүүлэн хүргэж ирсэн өмнөх үеийн хутагтын дацангийн хувраг олон багш нар ялангуяа зарлигийн ачит найман өвгөн багшийгаа Захчины найман гэгээн, Ойрадын шашин соёлын их эрдэнийг сайтар хамгаалсан Захчины найман баатар хэмээн магтаж шавийн адаг мөхөс миний бие багш нартаасөгдөн мөргөө. Түүх бол эхлэл төгсгөлгүй судлагдахуун ийм болоод хэн бүхний сонирхол татаж байдаг билээ. Өнөө үеийн бидний шашин соёлын төлөө анхаарал хандуулж судлан хийж буй ажлууд зуун жилийн дараа маш сонин түүх болж олон асуултанд хариулж, олон асуулт үүсгэж байх нь дамжиггүй юм.

Алтайн захчины хутагтын дацан буюу Рашигонзэглин хийд нь Зая бандида Огторгуйн Далай хутагт болон түүнийг залгамжлагч хутагт лам нартай ямар холбоотой болох ойрадын номын мэргэд, хутагт дээдсийн үлдээсэн өв, номын ёс уламжлалыг хэрхэн хадгалж ирсэн хурлын уншлага нь юу уншдаг, ямар онцлогтой талаар үзүүлэхийг зорьж хутагтын дацанд хадгалагдаж буй зарим нэгэн ном, судраар баримт болгон энэ илтгэлийг бичсэн.

Хутагтын үйлс дэлгэрч, Номын цагаан буян арвижих болтугай!

## Ном зүй

Далай, Ч. (2006). Ойрад монголын түүх. *Bibliotheca Oiratica*. III. Улаанбаатар.

Дармаабдраа (2008). Шашны алтан нарны гэрлийн илч тогтоон өгүүлсэн өлзий цагаан бадам номлол бүтээл өргөн дэлгэр сүмийн эх туурвил алтан эрхи хэмээх оршив. Эрхлэн хэвлүүлсэн На. Сүхбаатар, Х. Бямбажав. *Bibliotheca Oiratica*. VIII. Улаанбаатар.

Тэрбиш, Лхасрангийн (2008). Ойрадын бурханы шашны товч түүх. *Bibliotheca Oiratica*. IX. Улаанбаатар.

Раднаабдраа (2009). Равжамба Зая бандидын тууж Сарны гэрэл хэмээх оршив. Эрхлэн хэвлүүлсэн На. Сүхбаатар, Х. Бямбажав. *Bibliotheca Oiratica*. XII. Улаанбаатар.

## References

Dalai, Ch. (2006). History of Oirat Mongols. *Bibliotheca Oiratica*. III. Ulaanbaatar.

Dharmaabadraa (2008). Shashny altan narny gerliin ilch togtoon ögүүлсэн ölzii tsagaan badam nomlol бүтээл өргөн delger сүмийн ekh tuurvil altan erkhi khemeekh orshiv. Published by Na. Sukhbaatar, H. Byambajav. *Bibliotheca Oiratica*. VIII. Ulaanbaatar.

Terbish, Lhasrang (2008). A Brief History of Oirat Buddhism. *Bibliotheca Oiratica*. IX. Ulaanbaatar.

Radnaabadraa (2009). Ravjamba Zaya Bandid's novel called Moonlight. Published by Na. Sukhbaatar, H. Byambajav. *Bibliotheca Oiratica*. XII. Ulaanbaatar.